

1.5. Булган аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн 45 үзүүлэлтийн биелэлтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар тооцож үзэхэд 91.2 хувьтай байна. Үүнээс эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт 90.2 хувь, нийгмийн хөгжлийн үзүүлэлт 92.1 хувьтай тус тус хэрэгжжээ. Энэхүү үзүүлэлтүүдийн биелэлтийг аймгийн Статистикийн хэлтэс болон холбогдох байгууллагуудаас авч үнэллээ. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь үзүүлэлт | Зорилто т түвшин | Гүйцэтгэл | Хувь | Эх сурвалж |
|--|---|-------------|----------------|------------------|-----------|------|------------|
| | | | 2020 | 2023 | | | |
| ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ | | | | | | | |
| 1 | Дотоодын нийт бүтээгдэхүүн | сая төгрөг | 399,410.8 | 437,000.0 | 586,600.0 | 100 | СХ |
| 2 | Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн | сая төгрөг | 6.5 | 7.0 | 9.5 | 100 | СХ |
| 3 | Төсвийн орлого | сая төгрөг | 69,676.2 | 70,000.0 | 76,129.6 | 100 | СТС Х |
| 4 | Төсвийн зардал | сая төгрөг | 64,455.7 | 69,500.0 | 68,379.6 | 100 | СТС Х |
| 5 | Төсвийн тэнцэл | | 5,220.4 | 500.0 | 7,750.0 | 100 | СТС Х |
| 6 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь | хувь | 97.2 | 100 | 90.0 | 90.0 | ХХААГ |
| 7 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь | хувь | 66.1 | 75.0 | 76.0 | 100 | ХХҮГ |
| 8 | Ажилгүйдлийн түвшин | хувь | 12.2 | 8.5 | 5.5 | 100 | ХХҮГ |
| 9 | Ажиллах хүчний оролцооны хувь | хувь | 60.5 | 63.5 | 66.3 | 100 | ХХҮГ |
| 10 | Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь | хувь | 87.3 | 89.5 | 84.4 | 94.3 | ЭМДХ |
| 11 | Эдийн засгийн идэвхтэй хүн ам /ажиллах хүч/-ын нийгмийн даатгалд эзлэх хувь | хувь | 65.6 | 72.0 | 44.4 | 70.0 | НДГ |
| 12 | Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо | тоо | 198 | 350 | 474 | 100 | ХХҮГ |

| | | | | | | | |
|-----------------------------------|--|---------------|--------------|--------|---------|------|------------|
| 13 | Хэрэглээний үнийн индекс | индекс | 1.8 | 2.5 | 8.0 | 30.0 | СХ |
| 14 | Малын тоо | мянган толгой | 3395.7 | 3200.0 | 3600.0 | 70.0 | СХ |
| 15 | Хураан авсан үр тариа | мянган тонн | 47.4 | 53.1 | 54.5 | 100 | ХХААГ |
| 16 | Хураан авсан малын тэжээл бусад | мянган тонн | 8.0 | 9.5 | 17.3 | 100 | ХХААГ |
| 17 | Хураан авсан хүнсний ногоо | мянган тонн | 1.9 | 2.1 | 2.4 | 100 | ХХААГ |
| 18 | Хүлээн авах гадаад жуулчдын тоо | тоо | 7000 | 13000 | 10860.0 | 70.0 | БОАЖГ |
| 19 | Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо | тоо | 1239 | 1300 | 964 | 70.0 | СХ |
| 20 | Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь | хувь | 2.5 | 2.8 | 4.3 | 100 | ГХБХБ Г |
| 21 | Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь | хувь | 98.5 | 98.8 | 99.0 | 100 | ЭБЦД С |
| НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ | | | | | | | |
| 22 | Хүн амын дундаж наслалт | тоо | 73.5 | 73.8 | 74.4 | 100 | ЭМГ |
| 23 | Хүний хөгжлийн индекс | индекс | 0.677 /2019/ | 0.685 | 0.718 | 100 | СХ |
| 24 | Жендерийн тэгш бус байдлын индекс | индекс | 0.821 | 0.821 | 0.700 | 100 | ХХҮГ |
| 25 | Бүртгэгдсэн гэмт хэрэг | тоо | 350 | 300 | 392 | 70.0 | ЦГ |
| 26 | Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин | хувь | 54.0 | 58.0 | 32.3 | 70.0 | ЦГ |
| 27 | PM2.5 тоосонцорын жилийн дундаж агууламж | м кг/м3 | - | - | - | | УЦУ ОШТ |
| 28 | PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж | м кг/м4 | - | - | - | | УЦУ ОШТ |
| 29 | Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь | хувь | 39.4 | 39.7 | 39.7 | 100 | БОАЖГ |
| 30 | Дахин боловсруулах хог хаягдлын эзлэх хувь | хувь | 5 | 12.5 | 11.5 | 86.7 | БОАЖГ |

| | | | | | | | |
|----|--|----------|-------|------|-------|------|-------|
| 31 | Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь | хувь | 70.0 | 77.5 | 70.0 | 70.0 | БОАЖГ |
| 32 | 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин | промилль | 0 | 0 | 0 | 100 | ЭМГ |
| 33 | 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин | промилль | 16.2 | 16.0 | 18.3 | 70.0 | ЭМГ |
| 34 | 10000 хүн амд вируст гепатитын өвчлөл | тоо | 1 | 1 | 0.2 | 100 | ЭМГ |
| 35 | Тухайн жилийн товлот дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | хувь | 94.0 | 95.5 | 94.7 | 90.0 | ЭМГ |
| 36 | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь | хувь | 77.2 | 80.0 | 100.2 | 100 | ЭМГ |
| 37 | Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь | хувь | 76.7 | 79.0 | 95.0 | 100 | ЭМГ |
| 38 | Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь | хувь | 70.5 | 76.0 | 81.0 | 100 | ЭМГ |
| 39 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин | хувь | 59.3 | 63.9 | 66.7 | 100 | БШУГ |
| 40 | Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин | хувь | 86 | 89.6 | 87.0 | 70.0 | БШУГ |
| 41 | Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо | тоо | 30 | 26.2 | 26 | 100 | БШУГ |
| 42 | Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо | тоо | 25-28 | 25 | 23 | 100 | БШУГ |
| 43 | Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо | тоо | 474 | 500 | 505 | 100 | БШУГ |
| 44 | Оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо | тоо | 0 | 10 | 10 | 100 | ЦШ |

| | | | | | | | |
|---------------|-------------------------------|-----|-----|-----|-----|-------------|------|
| 45 | Төрийн цахим үйлчилгээний тоо | тоо | 383 | 450 | 461 | 100 | ТЗУХ |
| Дундаж | | | | | | 91.2 | |

Аймгийн ДНБ 586.6 тэрбум төгрөгт хүрч, 2020 оны суурь түвшинтэй харьцуулахад 46.8 хувиар өсөж, 2023 оны зорилтод түвшиндээ хүрсэн байна.

Аймгийн орон нутгийн төсвийн орлого 76.1 тэрбум төгрөгт хүрч, зорилтот түвшнээ хангасан бол бүх төр, төсвийн байгууллагууд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулсан.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 90.0 хувьтай байна. Энэ нь аймгийн хэмжээнд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас 20 төсөл дэмжлэг авснаас 5 төсөл хэвийн, 5 төсөл хэвийн бус, 2 төсөл хугацаа хэтэрсэн, 2 төсөл эргэлзээтэй, 6 төсөл муу зээлийн ангилалд байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл төлөлт 76.6 хувь, ажилгүйдлийн түвшин 5.5 хувьд хүрч 2023 оны зорилтот түвшиндээ тус тус хүрсэн байна.

2023 онд 350 байнгын ажлын байр бий болгохоор төлөвлөж, 474 байнгын ажлын байр бий болжээ.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь өмнөх оноос 5.1 пунктээр, эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд эзлэх хувь өмнөх оноос 27.6 пунктээр тус тус буурсан нь эрүүл мэндийн даатгалын хууль шинэчлэгдсэнээр эрүүл мэндийн даатгалыг 2019 оноос хойш нөхөн төлүүлэх шаардлагыг тавьж эхэлсэн. Үүнээс шалтгаалан ажилгүй, зорилтот бүлгийн, сайн дураар эрүүл мэндийн даатгал төлдөг иргэд нөхөн төлөлт болон тухайн жилийн төлөлтийг хийх боломжгүй болж хувь нь буурсан байна.

Хэрэглээний үнийн индекс 8 хувьтай гарч, зорилтот түвшнээсээ 5.5 пунктээр нэмэгдсэн нь бензиний үнэ өсөж, өргөн хэрэглээний барааны үнэ 2 дахин нэмэгдсэн нь нөлөөлжээ.

2023 оны жилийн эцэст 3600.0 мянган толгой мал тоолуулсан нь өмнөх оноос малын тоо буурсан үзүүлэлттэй боловч, зорилтод түвшиндээ хүрч чадаагүй байна. Учир нь малчид малаа эдийн засгийн эргэлтэд оруулахаас илүү малын тоон дээрээ ач холбогдол өгч байгаатай холбоотой байна. Цаашид малыг эдийн засгийн эргэлтэд оруулж, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр хураан авсан үр тариа, малын тэжээл бусад таримал, хураан авсан хүнсний ногооны хэмжээ зорилтот түвшнээ 100 хувь хангасан байна.

Идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн тоо 964-т хүрсэн байна. Ковид-19 цар тахлын улмаас үүдэлтэй аж ахуйн нэгжүүд үүд хаалгаа барьж, аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагын тоо өмнөх онуудаас буурсаар байгаа тул зорилтот түвшиндээ хүрч чадаагүй байна.

Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь 4.3 хувьд хүрсэн нь өмнөх оноос өсөж, зорилтод түвшиндээ хүрсэн байна. Мөн аймгийн хэмжээнд цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь 99.0 хувьд хүрч зорилтот түвшиндээ хүрлээ.

Хүн амын дундаж наслалт 74.4, хүний хөгжлийн индекс 0.718 хүрч, зорилтод түвшнээ хангаж, өмнөх оноос тус тус өссөн үзүүлэлттэй байна. Харин жендэрийн тэгш бус байдлын индексийг аймгийн хэмжээнд тооцоход учир дутагдалтай байгаа тул улсын хэмжээнд тооцсон 2022 оны үзүүлэлтийг авч үзлээ.

2023 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог бууруулахаар зорьсон ч зорилтот түвшиндээ хүрч чадаагүй байна. Мөн иргэдэд учирсан нөхөн төлүүлэлтийн түвшин буурсан үзүүлэлттэй байна. Байгаль орчны хамааралтай 2 үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй 70-86.7 хувийн хэрэгжилттэй байна.

Эрүүл мэндийн салбарын хувьд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, зорилтот түвшнийг давуулан биелүүлсэн байна.

Харин 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин өмнөх оноос өссөн нь эмнэлгийн орчин бус ахуйн орчинд нялхсын эндэгдэл гарсантай холбоотой байна.

Боловсролын салбарын суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин өмнөх оноосоо өссөн боловч, зорилтот түвшиндээ хүрч чадаагүй байна. Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог дээшлүүлэх сургалт арга хэмжээ авсны үр дүнд зорилтот түвшнээс 5 оноогоор давуулан биелүүлсэн байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хүрсэн түвшнийг зорилтот түвшинтэй харьцуулж дүгнэлээ.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн 21 үзүүлэлт, нийгмийн хөгжлийн 24 үзүүлэлт, нийт 45 үзүүлэлтийн биелэлт 91.2 хувьтай байна.

Нийт 45 үзүүлэлтийн 29 үзүүлэлт нь 2023 оны хүрэх түвшинд хүрч, 14 үзүүлэлт нь 30.0-94.3 хувиар биелсэн байна. Харин PM2.5 тоосонцорын жилийн дундаж агууламж, PM10 тоосонцорын жилийн дундаж агууламж гэсэн 2 үзүүлэлтийн биелэлтийг аймгаас гаргах боломжгүй байна.